



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/94

Хэрлэн сум

Монгол цэргийн өдрийг тэмдэглэн
өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Хэнтий аймагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх гэрээний 1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойн хүрээнд Батлан хамгаалах бодлого зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг орон нутгийн ард иргэдэд сурталчлах, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгоор “Монгол цэргийн өдөр”-ийн арга хэмжээг хөтөлбөрийн дагуу 2023 оны 3 дугаар сарын 15-ний өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 16-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. “Монгол цэргийн өдөр”-ийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, үйл ажиллагааны хөтөлбөрийг 2 дугаар, арга хэмжээнд зарцуулагдах зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардлагатай 5,991,400 төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.


4. Тусгай төлөвлөгөө гаргаж хөтөлбөрт заагдсан арга хэмжээнүүдийг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг зохион байгуулах ажлын хэсэгт, арга хэмжээнд зохион байгуулалттай оролцохыг “Чингис” цэргийн хүрээний анги, байгууллагын болон цэрэгжсэн байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ


А/94



Аймгийн Засаг даргын 2023
онь 02 дугаар сарын 14-ны
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 102 ЖИЛИЙН ОЙ,
“МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”-ИЙН АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Комиссын дарга:	Ж.Ганбаатар	Засаг даргын Тамгын газрын дарга
Орлогч дарга:	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга, Хурандаа
Гишүүдэд:	М.Бат-Очир	Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн Захирагч, Дэд хурандаа
	П.Мөнхбаатар	Хилийн цэргийн 0287 дугаар ангийн Захирагч, Хурандаа
	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга, Хурандаа
	Д.Батхүү	Цагдаагийн газрын дарга, Хурандаа
	Д.Хатанбаатар	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн дарга, Хурандаа
	Ц.Батсайхан	Монгол цэргийн нэгдсэн холбооны Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Цагдаагийн бэлтгэл дэд хурандаа
	А.Сарантуяа	Батлан хамгаалах, туслах нийгэмлэгийн Хэнтий аймгийн зөвлөлийн дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Эрдэнэсүх	Цэргийн штабын орон нутгийн хамгаалалтын бэлтгэл, сургалтын офицер, хошууч



Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 14-ны

дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 102 ЖИЛИЙН ОЙ,
"МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ИЙН АРГА
ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Д/д	Арга хэмжээний нэр	Оролцох бүрэлдэхүүн	Оролцох хүний тоо	Хугацаа	Зохион байгуулах бүрэлдэхүүн
3 дугаар сарын 15-ны (Лхагва гариг)					
1	Гар бөмбөг	Цэрэгжсэн байгууллагын албан хаагч	7	10.00	Цагдаагийн газар
2	Пауэрлифтинг хүндийг өргөлтийн тэмцээн	Нээлттэй тэмцээн	-	11.00	Аймгийн ЗДТГ, Цэргийн штаб, Хадун фитнес клуб
3	Дартс	Цэрэгжсэн байгууллагын удирдагууд	1	12.00	Онцгой байдлын газар
4	Шатар	Цэрэгжсэн байгууллагын албан хаагч	1	10.00	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
3 дугаар сарын 16-ны (Пүрэв гариг)					
5	Партизан Б.Пунцагийн хөшөөнд цэцэг өргөх	Аймаг, сумын удирдлага, Цэрэгжсэн байгууллагын дарга нар	1	10.00	Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб
6	Цэрэгжлийн спортын төрөлтийн тэмцээн	3 Цэрэгжсэн байгууллагын албан хаагч	3	11.00	Зэвсэгт хүчний 232 дугаар анги, Цэргийн штаб
7	Буудлагын тэмцээн	Цэрэгжсэн байгууллагын удирдлага, албан хаагч	3	15.00	Хилийн цэргийн 0287 дугаар анги, Цэргийн штаб
8	Ангийн бууны буудлагын тэмцээн	Ангийн буутай иргэд	1	16.00	Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 232 дугаар анги, Хилийн цэргийн 0287 дугаар анги
9	Шагнал гардуулах ажиллагаа	Цэрэгжсэн байгууллагын удирдлага, албан хаагч	-	18.00	Хэнтий аймгийн ЗДТГ, Цэргийн штаб, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар